



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 04 өдөр

Дугаар А/622

Номгон

Хүн ам, өрхийн бүртгэлийг сайжруулах
тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а" дахь заалт, Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.2, Статистикийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн өөрчлөлтийг 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 11 дүгээр сарын 01-ний өдрийн хооронд шинэчлэх ажлыг зохион байгуулсугай.

2.Харьяа сум багийн хүн ам, өрхийн мэдээллийн сангийн бүртгэлийг сайжруулах ажлыг чанартай зохион байгуулж, мэдээллийн чанарт хяналт тавьж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Харьяа сум багийн хүн ам, өрхийн мэдээллийн сангаас бэлтгэгдэж байгаа нийгмийн салбарын үзүүлэлтүүдийг хөдөлмөр, халамжийн үйлчилгээ, эрүүл мэнд, боловсрол, тээвэр, хөдөө аж ахуйн салбарын мэдээллүүдтэй тулгалт хийж нэгдсэн тоо мэдээлэлтэй байгаа эсэхэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Эрүүл мэндийн газар, Боловсрол, соёл, урлагийн газарт, сум, багийн "Хүн ам, өрхийн бүртгэлийн өөрчлөлт, шинэчлэлт"-ийг мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Статистикийн хэлтэс (Х.Ганзориг)-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

601210453

БАТЛАВ:
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА *[Signature]* ГАНЗОРИГ
2021 оны 10 сарын 07 өдөр

**ХҮН АМ, ӨРХИЙН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ЧАНАРЫГ
САЙЖРУУЛАХ САРЫН АЯНЫГУДИРДАМЖ**

Зорилго:

Монгол улсад Статистикийн байгууллага үүсэж хөгжсөний 97 жилийн ойг угтаж Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн чанарыг сайжруулж, өрх, иргэний мэдээллийн үнэн зөв байдлыг сайжруулах.

Хамрах хүрээ:

Сумын Засаг дарга, сумдын улсын бүртгэлийн байцаагч, Хөдөлмөр, халамжийн ажилтан, нийгмийн даатгалын байцаагч, нийгмийн бодлогын ажилтан, багийн Засаг дарга, Баянхонгор сумын бүртгэлийн ажилтнууд

Хугацаа:

2021 оны 10 дугаар сарын 01-ээс 2021 оны 11 дүгээр сарын 01 хүртэл

Ерөнхий зүйл:

2021 онд Нийгмийн статистикийн мэдээлэл, Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн чанарыг сайжруулж үйл ажиллагаандаа ашиглах зорилтыг тавин ажиллаж байна. Энэхүү аяны хүрээнд “Ковид-19” цар тахлын нөхцөл байдалд уялдуулан ХАӨМС-гийн баяжилтыг өрхийн гишүүдтэй утсаар холбогдож шинэчлэн сайжруулах, мэдээллийн анхан шатны бүртгэлийг чанаржуулах нэг сарын аяныг зарлаж байна.

ХАӨМС-д 2021 онд шинээр төрсөн 287 хүүхэд, 64 нас барсан иргэний мэдээллийг оруулаагүй, шилжиж ирсэн өрх, хүн амын бүртгэл хийгээгүй, шилжиж явсан өрх, хүн амын мэдээллийг баталгаажуулаагүй, өрхийн сууцны нөхцөл байдал, хувь хүн, иргэний мэдээллийг шинэчлээгүй зэрэг дутагдал арилсан байна.

ХАӨМС-н мэдээлэл баяжилттай холбоотойгоор дараах анхаарах зүйлс байна.

1. Төрөлт, нас баралтыг 7 хоног тутамд авч мэдээллийг баяжуулах
2. Өрх, иргэдийн холбогдох утасны дугаар жил бүр шинэчлэгдэж байгаа тул гар утасны дугаарыг шинэчлэх, цар тахлын хүрээнд байнга холбогдох утсыг шинэчилсэн байх.
3. Шилжилт хөдөлгөөнийг 7 хоног бүр авч өрх, хүн амын шилжилтийг ХАӨМС-д баталгаажуулах.
4. Шилжин ирж байгаа өрх, иргэдийн мэдээллийг ХАӨМС-д бүртгэж авах, өрхийн байршил тэмдэглэх.

Хүрэх үр дүн: Сум багийн ХАӨМС-ын баяжилт хийгдэж иргэдийн мэдээлэл бүрэн шинэчлэгдсэн байна.